



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 4/20

Хажуу шинэ ус

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дүгээр хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Эрүүл агаар, идэвхтэй хөдөлгөөн” сэдэвт Мөсны баярын арга хэмжээг 2022 оны 02 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсугай.

2. Мөсний баярын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Сарангэрэл	(Засаг даргын орлогч)
Гишүүд	Т.Уранчимэг	(Ерөнхий боловсролийн сургуулийн захирал)
	А.Алтанчимэг	(Цэцэрлэгийн эрхлэгч)
	Н.Долгорсүрэн	(Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	М.Ганбуд	(Соёлын төвийн эрхлэгч)

3. “Эрүүл агаар, идэвхтэй хөдөлгөөн” сэдэвт арга хэмжээг хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан төрийн албан хаагчид, иргэдийн дунд нээлттэй хэлбэрээр оролцоог жигд ханган зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН